

**“ЭРДЭНЭС МОНГОЛ” НЭГДЛИЙН 2020-2022 ОНУУДЫН НЭГТГЭСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХАРААТ БУС ХӨНДЛӨНГИЙН АУДИТ ХИЙЖ  
ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

1	Зөвлөх үйлчилгээний нэр	“Эрдэнэс Монгол” нэгдлийн 2020-2022 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд хараат бус хөндлөнгийн аудит хийж гүйцэтгэх.
2	Захиалагч	“Эрдэнэс Монгол” ХХК
3	Зөвлөх үйлчилгээний зорилго	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2020-2022 онуудын нэгтгэсэн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит гүйцэтгүүлэх хараат бус олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сүлжээ компани (цаашид “гүйцэтгэгч” гэх)-ийг сонгон шалгаруулах зорилготой.
4	Ажлын цар хүрээ	“Эрдэнэс Монгол” нэгдлийн 2020-2022 онуудын нэгтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын холбогдох стандарт, заавар, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар аудит хийж, дүгнэлт гарган баталгаажуулах.
5	Аудит хийж гүйцэтгэх үндсэн шаардлагууд	<ol style="list-style-type: none"> <li>1. Ажил үйлчилгээг Аудитын олон улсын стандарт (International Standards on Auditing) болон Монгол улсын Аудитын тухай хууль тогтоомжийн дагуу үзүүлэх,</li> <li>2. Аудитын шалгалтын явцад илэрсэн аливаа чухал асуудал, Аудитын дүгнэлтэд орох боломжит өөрчлөлт, дотоод хяналтын системийн томоохон дутагдлууд, залруулга хийгдээгүй өөрчлөлт болон бусад асуудлыг цаг тухайд нь захиалагчийн удирдлагад мэдээлэх,</li> <li>3. Захиалагчийн удирдлагад түүний объектод нэвтрэх талаар урьдчилан мэдэгдэх ба тус ажлыг зохион байгуулахад шаардлагатай мэдээллийг тухай бүр хүргүүлэх, объектод нэвтрэх тогтоосон журам болон бусад дотоод дүрмийг дагаж мөрдөх,</li> <li>4. Аудит болон захиалагчийн харилцаа холбоог үр дүнтэй болгох, мэдээллийн солилцооны аюулгүй байдлыг хангах үүднээс онлайн шугам ашиглах,</li> <li>5. Энэхүү ажлын даалгаварт тусгагдсан бүх төрлийн ажил үйлчилгээний дагуу гэрээг биелүүлэхтэй холбоотойгоор гүйцэтгэгчээс гарах бүх зардал гэрээний үнэд багтсан байх ёстой.</li> <li>6. Ажил үйлчилгээ үзүүлэх хугацаа болон байршил: Эхлэх хугацаа: 2023 оны ..-р сарын ..-ний өдөр Дуусах хугацаа: 2023 оны ..-р сарын ..-ний өдөр Байршил: Улаанбаатар хот, СБД 1-р хороо, Моннис товер, 15 давхар</li> </ol>
6	Аудитын санал дүгнэлтэд багтаах асуудал	<ol style="list-style-type: none"> <li>1. Компаний удирдлагын үүрэг хариуцлага, аудиторын үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл,</li> <li>2. Нэгдлийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь СТОУС болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журмын дагуу байгууллагын санхүүгийн тайланг материаллаг бүх үзүүлэлтээр үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэх талаар аудитын дүгнэлт өгөх,</li> <li>3. Нэгдлийн нэгтгэсэн санхүүгийн тайлагнал болон нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дотоод хяналтыг үнэлэх, хяналтын эрсдэл болон материаллаг сул тал оршин байгаа эсэхийг тодорхойлох,</li> <li>4. Өмнөх аудит, бусад төрлийн хяналт шалгалтын зөвлөмжийн биелэлт, хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн эсэхийг тодорхойлох,</li> </ol>

		<p>5. Аудитын тайланд бусад мэдээлэл, тайлбарыг оруулж болно.</p> <p>6. Аудитлагдсан тайланг англи, монгол хэл дээр бэлтгэнэ.</p>
7	Менежментийн захидал бэлтгэх	<p>1. Компанийн удирдлага, менежмент, дотоод хяналтын системийн үр ашгийг үнэлэх,</p> <p>2. Санхүүгийн менежментэд ажиглагдсан дотоод хяналттай холбоотой сул талыг тодорхойлох, сул талыг арилгах санал зөвлөмж өгөх,</p> <p>3. Аудитын ажлын үед шалгасан нягтлан бодох бүртгэлийн данснууд, процедур, систем болон хяналт зөрчсөн жишээн дээр тайлбар бичих, мөн таарахгүй байгаа зардал болон системийн сул талтай холбоотой эсэхийг тодорхойлох,</p> <p>4. Нягтлан бодох бүртгэл болон программ хангамжийн хувьд алдаа дутагдал, сул тал байгаа эсэхийг тодорхойлох,</p> <p>5. Өмнөх аудитын тайланд өгсөн санал дүгнэлтийн хэрэгжилтийн байдлын талаар тайлагнах,</p> <p>6. Аудитын үр дүнд, санал дүгнэлтэд өгөх менежментийн хариу тайлбарыг тусгана.</p>
8	Техникийн шаардлага	<p>1. Аудитын байгууллагын хараат бус, найдвартай байдлыг хангуулах, багийн гишүүдийг ашиг сонирхлын болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аудит хийж байгаа байгууллагатай санхүүгийн ашиг сонирхолгүй, удирдлагаас бие даасан, шударга байх,</p> <p>2. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн удирдлагын багт байгаа эрх бүхий албан тушаалтнуудтай санхүүгийн болон бизнесийн холбоогүй байх, ямар нэгэн харилцаа холбоо байгаа тухайгаа мэдэгдэх.</p>
9	Аудитын компанид тавигдах шаардлага	<p>1. Олон улсын нэр хүнд бүхий аудитын хуулийн этгээд эсвэл түүний салбар байна,</p> <p>2. Аудитын компани нь уул уурхайн компаниудын санхүүгийн тайлан болон нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж байсан туршлагатай байх,</p> <p>3. Аудитын ажлыг гүйцэтгэх багт санал болгосон ажилтнуудын анкетыг оруулах, аудитын компанид ажиллаж байгаа ажилчдын албан тушаал, үүрэг хариуцлага, ажилласан жил, ижил төрлийн ажлын туршлага, боловсрол, гишүүнчлэл, сүүлийн 3 жилд гүйцэтгэсэн ажил үүрэг хариуцлага гэх мэт мэдээллийг оруулна.</p>

Захиалагч шаардлагатай гэж үзвэл ажлын даалгаварт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ХЯНАСАН:  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Д.ПҮРЭВСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:  
НБТХ-ИЙН НЯГТЛАН БОДОГЧ

Т.БАЯРНЯМ